

БАТЛАВ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ХУРАНДАА Д.ЗАГДЖАВ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХОЁР ДАХЬ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
/2022 ОН/

2022.02.14

Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгархуулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:					
4.1.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтны мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх;	1	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх;	2022 он	Холбогдох хууль журмын хүрээнд албан тушаалын томилгоо хийгдсэн байна.	Захиргааны удирдлагын газар
	2	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах;	2022 он	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана	Захиргааны удирдлагын газар
4.1.1.7. Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;	3	ШШГБ-ын алба хаагчдын ёс зүйтэй холбогдуулан гаргасан өргөдөл, гомдол мэдээллийн дагуу хяналт шалгалт явуулж, холбогдох арга хэмжээ авах;	2022 он	Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлага дээшилж, албан хаагчийн зөрчил, дутагдал буурсан байна.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги салбар нэгжийн салбар ёс зүйн хороо
	4	ШШГБ-ын хэмжээнд албан хаагчийн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой зөрчлийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх;	2022 он	Албан хаагчийн гаргасан авлига, ашиг сонирхлын зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлж, түүнд судалгаа шинжилгээ хийсэн байна.	Хяналт шалгалт, аюулгүй байдлын газар

4.1.1.9. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох боломжийг сайжруулах;	5	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Хил хамгаалах ерөнхий газар, Хас банктай мэдээлэл солилцох ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх;	2022 он	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээллийг шуурхай хүлээн авах чиглэлээр хуулийн байгууллага болон арилжааны банк хооронд мэдээлэл солилцох ажлыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.	Шийдвэр гүйцэтгэх алба
4.1.1.10. Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх;	6	"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад зохион байгуулах сургалтын хөтөлбөр"-ийг баталж, хэрэгжилтийг ханган ажиллах;	2022 он	Батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг тогтмол чанартай зохион байгуулж, албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.	Захиргааны удирдлагын газар
	7	АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдыг хамруулсан байх;	2022 он	Албан хаагчид сургалтад хамрагдсан байна.	Хяналт шалгалт, аюулгүй байдлын газар
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:					
4.1.2.4. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох;	8	Хяналт шалгалтын үр дүнд илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргуулахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор үүрэг даалгавар өгөх;	2022 он	Дотоод хяналт шалгалт сайжирч, анги, байгууллагын үйл ажиллагаа хуулийн хэрээнд явагдана.	Хяналт шалгалт, аюулгүй байдлын газар
	9	Анги, байгууллага нь дотооддоо хяналт шалгалтын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх, түүний үр дүнд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах байдлаар хяналт шалгалтын үйл ажиллагааг тогтмолжуулах;	2022 он	Хяналт шалгалтын үйл ажиллагаа тогтмолжиж, бэхжсэн байна.	Хяналт шалгалт, аюулгүй байдлын газар
4.1.2.7. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	10	ШШГБ-аас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжийн талаар хөндлөнгийн байгууллагаар "Хэрэглэгчийн үнэлгээ" хийлгэх;	2022 оны 4 дүгээр улиралд	ШШГБ-ын хэмжээнд үйлчлүүлж буй хэрэглэгч, иргэд, олон нийтийн хандлага, түүнд нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйл, цаашид анхаарах асуудлыг тодорхойлж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.	Хяналт шалгалт, аюулгүй байдлын газар

Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:					
4.1.3.2. Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зурцуулалтын хөндлөнгийн хяналт хариуцлагыг дээшлүүлэх;	11	Эрсдэлтэй гэж үзсэн төсөвт анги, байгууллагын төсвийн зарцуулалтад хөндлөнгийн хяналт хийх;	2022 он	Төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр ашиг сайжирсан байна.	Санхүү, үйлдвэр, хөрөнгө, оруулалтын газар
4.1.3.3 Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах;	12	Төрөөс нөхөн төлбөр олгуулахыг хүссэн өргөдлийг шийдвэрлүүлж, нөхөн төлбөрийг шилжүүлэх;	2022 он	Мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг хэвшүүлсэн байна.	Шийдвэр гүйцэтгэх алба
	13	Төлбөр төлөгчөөр нөхөн төлбөрийг буцаан төлүүлэх ажлыг зохион байгуулах;			

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР